

“МОНГОЛ УЛС БА ХҮЙТЭН ДАЙН”

*К.Дэмбэрэл**

Монголын гадаад харилцаа судлаачдын “Пакс Монголика” (PAX MONGOLICA) Төрийн бус байгууллага МУИС дээр хэрэгжиж буй Иргэний боловсрол төсөлтэй (СЕР) хамтран “Монгол Улс ба Хүйтэн дайн” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг Улаанбаатар хотноо 2004 оны 03 сарын 19-20-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Хуралд оролцогч байгууллагууд:

1. Монголын гадаад харилцаа судлаачдын “Пакс Монголика” (PAX MONGOLICA)
2. Хүйтэн дайны түүхийн олон улсын төсөл (CWINP)
3. НАТО ба Варшавын Гэрээний түүхийн харьцуулсан төсөл (РНР)
4. АНУ-ын Үндэсний Аюулгүй Байдлын архив (ТББ)
5. Жорж Вашингтоны Их сургууль

Хурлыг ивээн тэтгэгчид:

1. Иргэний Боловсрол Төсөл (СЕР)
2. Монгол Улс дахь АНУ-ын ЭСЯ
3. Соросын сан
4. АНУ-ын Монгол судлалын төв

Тус бага хуралд тавигдсан илтгэлүүд судалгаа шинжилгээний өндөр түвшинд болсныг хуралд оролцогчид санал нэгтэй дүгнэж байлаа.

Хүйтэн дайны түүхийн олон улсын төсөл (CWINP), НАТО ба Варшавын Гэрээний түүхийн харьцуулсан төсөл (РНР)-үүд нь Зүүн Европын хуучин социалист орнууд, ОХУ, БНХАУ, Монгол, Вьетнамд тус тус ажлын хэсэгтэйгээр судалгаагаа явуулдаг. 1945-1990 оны олон улсын харилцааны болон дээрх орнуудын улс төрийн дотоод амьдралын талаарх судалгааг тухайн орны архивын материалд тулгуурлан явуулдаг төдийгүй улс төрийн томоохон үйл явдлуудад дүн шинжилгээ хийдэг. Эдгээр төслүүд нь хэрэгжүүлж буй орнуудынхаа өнгөрсөн хугацааны түүхийг иж бүрнээр нь гарган харуулах, харилцан материал солилцох, судлаачдын арга барилыг өргөжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.

Бага хуралд АНУ болон Европын орнуудаас нийт 14 судлаач, Монголын талаас 11 судлаачид оролцон дараах сонирхолтой илтгэлүүд тавьж хэлэлцүүлээ. Үүнд:

*К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

1. К.Дэмбэрэл (ШУА-ийн ОУСХ-гийн эрдэм шинжилгээний ажилтан, “Пакс Монголика” Холбооны гүйцэтгэх захирал) “Ким Ир Сений талаарх Монголын архивын материалууд”
2. Д.Шүрхүү (ШУА-ийн ОУСХ-гийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, “Пакс Монголика” Холбооны УЗ-ийн гишүүн) “1960-аад оны Монгол-Хятадын харилцаа”
3. Б.Баабар (Зүүн Хойд Азийн нийгэмлэгийн тэргүүн, нийтлэлч) “Лин Бяогийн хэрэг: Говьд тохиосон үхэл”
4. Ж.Төгсжаргал (УИХ-ын архивын шинжээч, “Пакс Монголика” Холбооны гишүүн) “Лин Бяогийн хэрэг: Монголын талын нотолгоо”
5. Ивет Цинь (Жорж Вашингтоны Их сургууль) “Монгол улс НҮБ-д элссэн ба АНУ-аар хүлээн зөвшөөрүүлэх талаар Ж.Кеннедийн засаг захиргааны үед гарсан хямрал”
6. Жим Хершберг (Жорж Вашингтоны Их сургууль) “Жонсон, Никсон нарын Америк, Монголын харилцааг хэвийн болгох оролдлого бүтэлгүйдсэн нь”
7. Балаж Салонтай (Төв Европын Их сургууль) “Монгол маягийн дипломат бодлого: 1958-1963 оны Монголын гадаад, дотоод бодлого”
8. Д.Мөнх-Очир (БХЯ-ны Стратегийн судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, “Пакс Монголика” Холбооны гишүүн) “1970-аад оны Монгол-Ираны харилцааны идэвхжилт: Зөвлөлтийн чиг шугамаас зөрсөн эсэх тухайд”
9. Н.Алтанцэцэг (МУИС, ОУХС-ийн захирал, “Пакс Монголика” Холбооны УЗ-ийн гишүүн) “Монголыг Хятадын бүрэлдэхүүнд оруулах гэсэн Мао Зэдуны оролдлого”
10. О.Батсайхан (ШУА-ийн ОУСХ-гийн ЭШТА, “Пакс Монголика” Холбооны УЗ-ийн гишүүн) “Монголын тусгаар тогтнолын асуудлаар Зөвлөлтийн удирдлагатай хийсэн хэлэлцээрүүд”
11. Ч.Болдбаатар (МУИС, Улс төрийн тэнхим) “Содномын Аварзэд Зөвлөлтийн эсрэг үзэлтэн байсан уу?”
12. Лю Сяюань (Iowa-гийн Их Сургууль) “Лагерийн улс төрийн бүтэц: Мао, Сталин ба Монголын тусгаар тогтнол”
13. Малгорзата Гнойнска (Жорж Вашингтоны Их сургууль) “Монголын талаарх Польшийн баримтууд”
14. Войтек Мастни (НАТО ба Варшавын Гэрээний түүхийн харьцуулсан төслийн (РНР) удирдагч) “Монгол Улс ба Варшавын Гэрээний Байгууллагын талаарх Зүүн Европ дахь баримтууд”
15. А.Түвшинтөгс (БХЯ-ны Стратегийн судалгааны хүрээлэнгийн дэд захирал, “Пакс Монголика” Холбооны УЗ-ийн гишүүн)

“Монгол улсын Батлан хамгаалах яам ба Варшавын Гэрээний Байгууллага”

16. Ц.Гүрбадам (МУИС, ОУХС-ийн багш, дипломатч, “Пакс Монголика” Холбооны УЗ-ийн гишүүн) “Ю.Цэдэнбал ба Монголын бүрэн эрхт байдал”
17. Ц.Жамбалсүрэн (МУИС, Түүхийн судалгааны хүрээлэнгийн багш) “1984 он: Ю.Цэдэнбалыг албан тушаалаас нь зайлуулсан нь”
18. Атилла Ковач (ELTE) “1989-1990 оны Монголын ардчилсан хувьсгал”
19. Сергей Радченко (СЕР) “А.И.Филатова: Монголын дотоод улс төрийн нөхцөл байдал”

Эдгээр илтгэлээс гадна Хүйтэн дайны түүхийн олон улсын төслийн (CWINP) удирдагч Х.Остерманн, НАТО ба Варшавын Гэрээний түүхийн харьцуулсан төслийн (PHP) удирдагч В.Мастни, АНУ-ын Үндэсний Аюулгүй Байдлын архивын (ТББ) захирал М.Бёрн нарын өөрсдийн төслийн зорилго, чиглэл, үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж Монголын эрдэмтэн судлаачидтай санал солилцлоо.

Дээрх төслийн шугамаар хэвлэгдэн гардаг сэтгүүлүүд болон архивын материалуудыг CD-д бичиж авчирсан нь Монголын судлаачдад олзуурхууштай зүйл байлаа. Монголын гадаад харилцаа судлаачдын “Пакс Монголика” Холбоо нь эдгээр төслүүдтэй үргэлжлүүлэн хамтран ажиллахаар тохирлоо.